

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-26
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	27-178
	1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	30-84
	2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	84-86
	3. Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	86-91
	4. “Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/	91-96
	5. “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан/	96-103
	6. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр 2020.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	103-131
	7. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	131-154
	8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	154-157
	9. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	157-164
	10. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	164-178

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы
2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Хураангуй тэмдэглэл

Арав.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар “Их хуралдай” танхимаас, Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн А.Амармөрөн, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одгэрэл, Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн Д.Нэргүй нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар “Их хуралдай” танхимаас, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир цахимаар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Л.Энх-Амгалан, Ц.Мөнхцэцэг, Л.Мөнхбаатар, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг “Их хуралдай” танхимаас, Оюуны өмчийн газрын Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ цахимаар тус тус хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 27
Бүгд: 63
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг “Их хуралдай” танхимд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн референт Б.Туул, шинжээч М.Номиндулам, Э.Сувд-Эрдэнэ нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн ахлах референт Ч.Тунгалаг, референт С.Мөнхтөр, шинжээч Б.Эрдэнэбаяр нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 04 минут үргэлжилж, ирвэл зохих 74 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 78.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

Дэлгэрэнгүй тэмдэглэл

***Арав.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/***

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал анх 1993 онд Зохиогчийн эрхийн тухай хуулийг баталсан байдаг бөгөөд Зохиогчийн эрхийн олон улсын гэрээ, конвенц болон нийгэм, эдийн засгийн харилцааны шинэчлэлтэй уялдуулан 2006 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

Гэвч хуулийг хэрэгжүүлэх явцад оюуны бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглах, хуулбарлах, хууль бусаар орлого олох явдал эрс өсөн нэмэгдэж, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цахим болон харилцаа холбооны бусад сүлжээ, өргөн нэвтрүүлэг, олон сувгийн дамжуулагч, дуу хөгжим, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зохиогч, эрх эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх, хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлага үүсээд байна.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд доор дурдсан шинэлэг зохицуулалтыг тусган боловсрууллаа. Үүнд:

Нэгдүгээрт, Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааны хувьд гэрэл зураг болон хавсарга уран бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн 25 жилийн хугацаанд, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлсний дараа жилийн 01 дүгээр сарын 01-нээс эхлэн 50 жилийн хугацаанд, бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл нийтлэгдсэний дараа жилийн 01 дүгээр сарын 01-нээс эхлэн 50 жилийн хугацаанд тус тус хамгаалахаар тусгах.

Хоёр. Зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг буюу бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдлуудыг нарийвчлан тодорхойлох, түүнчлэн бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах, шударга ашиглалтын нөхцөлийг тодорхойлох.

Гурав. Үүсмэл бүтээл, албан үүргийн дагуу туурвисан бүтээл, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл, компьютерийн программ, мэдээллийн сан, дүрслэх урлагийн бүтээл, архитектурын бүтээлийн зохиогчийн эрхийн онцлогийг дэлгэрэнгүй тусгах.

Дөрөв. Бүтээл ашиглах, онцгой эрхийг шилжүүлэх, эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг лиценз олгох замаар бусдад бүтээл ашиглуулах үндсэн арга хэлбэрийг тодорхойлох, түүнчлэн бүтээл ашиглах эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээний үндсэн нөхцөлийг нарийвчлан тусгах.

Тав. Цахим орчноос гадна харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах, бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээний талаар нэмж тусгах.

Зургаа. Зохиогч, эрх эзэмшигчдийн эрхээ төлөөлүүлэн, хэрэгжүүлэх, хамгаалуулах үндсэн хэлбэр болох хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Тодруулбал хамтын удирдлагын байгууллагад тавих шаардлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаандаа ил тод, шуурхай байдал болон үнэн бодит зөв мэдээллийг хангаж ажиллах эрх зүйн орчныг бий болгож, уг харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах боломжийг бүрдүүлэх.

Долоо. Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэн хуулбарлах. Хуулбарыг хэл дамнуулан солилцох, нийтэд түгээх болон нийтийн хүртээл болгоход зохиогчийн эрхийг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.

Найм. Бүтээл ашиглалтын тарифыг хянаж, батлах чиг үүрэг бүхий зохиогчийн эрхийн зөвлөлийг байгуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлох.

Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, судлаачдаас санал авч холбогдох саналыг тусгасан.

Түүнчлэн хуулийн төслийг Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас хэрэгжилтийг нь хангадаг олон улсын гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэх талаар Дэлхийн оюуны өмчийн газрын олон улсын товчооноос урьдчилсан саналыг авч хуулийн төсөлд тусгасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Х.Нямбаатар сайдад.

Одоо төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Ц.Сандаг-Очир гишүүнийг.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурал Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд зохицуулах харилцаа өөрчлөгдсөн төдийгүй, зохиогчийн эрхийн салбарт гарч байгаа өөрчлөлт, шинэчлэлтийг тусгах, зохиогч, эрх эзэмшигч, тоглогч, уран бүтээлч, программ бүтээгч, өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон суваг дамжуулагчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, дуу авиа бүхий дүрс бүтээлийн зохиогчийн эрхийн асуудлыг зохицуулах, компьютерийн программ зохиогч болон мэдээллийн сангийн зохиогчийн эрхийн зохицуулалтыг шинээр нэмэх, олон улсын нийтлэг жишигт тулгуурлан бүтээл ашиглуулах хэлбэр, нөхцөлийг нарийвчлан тодорхойлох, хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хуулбарлах зэрэг зохицуулалтыг тусган Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан монгол үндэстний ардын урлагийн төрөл болох ардын дуу, бүжиг, үлгэр, домог, тууль, өв соёлыг болон гадаад улсад зохиогчийн эрх зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх асуудал төсөлд туссан талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд. Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Хишгээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Х.Болорчулуун гишүүнээр тасаллаа. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Энэ зохиогчийн эрх бол хүний оюуны хөтөлбөрийг хамгаалж байгаа асуудал л даа.

Ялангуяа техник, технологи нь хөгжиж байгаа үед улс орны хөгжлийн гол түлхүүр бол яах аргагүй энэ зохиогчийн эрх, энэ патентыг хамгаалах асуудал.

Монгол Улсад бүртгэлтэй, олон улсын хэмжээнд эрх нь бүртгэгдсэн хэдий хэмжээний ийм зохиогчийн эрх байдаг юм бэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь, энэ хууль гарснаараа оюуны бүтээлийг хулгайлсан, зохиогчийн эрхийг ашигласан ийм хүмүүс болон байгууллагад ямархуу хариуцлага ногдуулах юм бэ?

Хамгийн гол нь тэр хариуцлага маш тодорхой байх ёстой. Зөрчлийн хуулиар юм уу, Эрүүгийн хуулиар юм уу. Энэ талаар тайлбарлаж өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Цахимаар хэн нь хариулах билээ. Оюуны өмчийн газрын дарга Энхсүх хариулна. Баттөмөрийн Энхсүх дарга.

Д.Бат-Эрдэнэ: Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Д.Бат-Эрдэнэ байна. Эрхэм гишүүн Х.Болорчулуун гишүүний асуултад ариулья.

Сүүлийн 3 жилийн байдлаар зохиогчийн эрх 3070 ширхэг бүртгэгдсэн байгаа. Тухайлах юм бол 2020 онд 1045 ширхэг, 2019 онд 1030 ширхэг, 2018 онд мянга орчимд бүртгэгдсэн байгаа.

Зохиогчийн эрхийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээдэг байгаа. Иргэнийг таван зуун нэгж, аж ахуйн нэгжийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоод, хууль бусаар олсон хөрөнгө, орлого, техник хэрэгслийг хураах гэсэн 6 төрлийн албадлагын арга хэмжээ авдаг байгаа.

Тэгээд хохирлын хэмжээ 50 сая төгрөгөөс дээш гарсан тохиолдолд Эрүүгийн хуулиар ажиллагаа хийгддэг.

Ер нь зохиогчийн эрхийг сайн дурын үндсэн дээр Оюуны өмчийн газар бүртгүүлж гэрчилгээ авдаг байгаа. Бусад тохиолдолд зохиогчийн эрхийг бүртгүүлэхгүйгээр зохиогчийн эрх автоматаар үүсгэгддэг. Оюуны өмчийн газарт бүртгүүлж гэрчилгээ авах шаардлагагүй байдаг.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн. 4 гишүүнээр тасалсан. Цахимаар.

Л.Энх-Амгалан: Би хэд хэдэн зүйл тодруулахыг хүсэж байгаа юм.

Монгол Улсад зохиогчийн эрх хамгийн их зөрчигддөг ийм улс орнуудын тоонд бид ордог. Ер нь оюуны өмчийн хулгай газар авсан ийм л зохицуулалт муутай ийм улс орон болчихоод байгаа шүү дээ. Бид нар чинь. Одоо наад зах нь гэхэд л бид төр засгаасаа авахуулаад л Microsoft-ийн лицензтэй программ хэрэглэдэг үү, хэрэглэдэггүй юу? Энэ Монголын төрд ажиллаж байгаа 192 мянган хүний хэрэглэж байгаа программ лицензтэй юу, лицензгүй юу гээд ганцхан асуулт асуухад л бид сөхөрнө л дөө. Энэ олон нэр хүндтэй компаниудын өмнө. Нэгд.

Хоёрт, жилд ер нь Монголд энэ оюуны өмчийн хулгайгаас болж тодорхой зохиогчид ирж байгаа хохирол гэдэг юм уу, эдийн засагт ирж байгаа хохирол гэдэг юм уу, яг энэ чиглэлээр хийсэн ер нь судалгаа, тооцоо ер нь манай улсад байна уу? Бид яг ямар боломжуудыг алдаж байна гэж. Хоёрт.

Гуравдугаарт нь, энэ фэйсбүүк, цахим орчны оюуны хулгай маш их ихсэж байна гэж ярьж байна л даа. Цахим орчны. Тэгэхээр энэ чиглэлээр яг энэ орж ирж байгаа хуулийн зохицуулалт дээр ер нь ямархуу зохицуулалтууд орж байгаа вэ гэдэг зүйлүүдийг тодруулъя гэж бодож байна. Тэгээд нэмж тодруулна.

Г.Занданшатар: П.Сайнзориг. Пүрэвжавын Сайнзориг.

П.Сайнзориг: Л.Энх-Амгалан гишүүнд баярлалаа.

Ер нь мэдээж оюуны өмчийн салбар бол ихээхэн чухал салбар байж байгаа. Энэ дээр аж үйлдвэрийн өмчийн патентын хамгаалалт. Эргээд зохиогч буюу бидний хамгийн энгийн ойлголтоор ном зохиол, дуу хөгжим ч гэдэг юм уу, энэ зүйлүүдийг туурвиж байгаа этгээдүүдийн эрхийг хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг асуудал эргээд эдийн засгийн суурь бүтцийг өөрчлөх буюу эдийн засгаа бас төрөлжүүлэн солонгоруулах асуудлын бас суурь нь байгаад байгаа юм.

Нийт дэлхийн улс орнуудын оюуны өмчийн эрхийн хамгаалалтаас үндэслэж байж аж үйлдвэр хөгжих үү, эргээд хөнгөн үйлдвэрлэл ч гэдэг юм уу, IT технологийн салбар хөгжих үү гэдэг асуудал нь эргээд хэрхэн яаж оюуны өмчийг хамгаалж байгаа юм бэ гэдэг асуудал байгаа.

Нөгөө талдаа гадаадын хөрөнгө оруулагчид ч гэсэн үүнийг сонирхдог. Эргээд Монгол Улсад тодорхой салбарт буюу IT-гийн салбар ч гэдэг юм уу, хөрөнгө оруулах гэхээр ер нь оюуны өмчийн хамгаалалт ч гэдэг юм уу, эрхийн хамгаалалтын асуудал чинь сул байна. Энэ ойлголтууд олон улсын жишиг хандлагадаа нийцэхгүй байна гэдэг зүйлүүд удаа дараа тавигддаг.

Энэ хүрээндээ мэдээж энэ хуулийн төслийг боловсруулж олон улсын гэрээ конвенц, дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлж хуулийг оруулж ирж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Мэдээж энэ хуулийг бас боловсруулах нэг үндэслэл бол таны хэлж байгаа энэ техник, технологийн хөгжилтэй холбоотой байгаа. Үүнийг дагасан

оюуны өмчийн бүтээлийг олон нийтэд хүргэх олон төрлийн үйл ажиллагаануудыг хэрхэн яаж зохицуулах вэ. Үүнээс үүсэж байгаа тэр эдийн засгийн үр өгөөжийг хэрхэн яаж хуваарилах вэ гэдэг асуудлууд энд эрхийн төрлүүд дээрээ хамаараад нэлээн зохицуулалтуудыг нь нарийвчилж орж ирж байгаа.

Дээрээс нь мэдээж энэ оюуны өмчийн хохирлын хэмжээг манай Оюуны өмчийн газраас нэмэх байх. Ер нь яг эцэслэн тогтоосон зүйл байхгүй байгаад байгаа.

Хоёрдугаарт, мэдээж оюуны өмчийн гэмт хэрэг зөрчлийг шийдэх, цаашдаа ер нь оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэг асуудал хохирлын үнэлгээ буюу оюуны өмчийг үнэлэх асуудал манайд тодорхойгүй явж.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг асуулт асууна.

Ц.Мөнхцэцэг: Энэ маш их чухал хууль орж ирж байна. Тэгэхээр Оюуны өмчийн тухай хууль 2006 оноос хойш гэдэг маань 14 жилийн дараа энэ хууль орж ирж байна.

Тэгэхээр энэ хугацаанд аж үйлдвэрийн болон оюуны өмчийн маш олон үйл ажиллагаа, харилцаанууд шинэчлэгдсэн байгаа. Тэр дундаа түрүүн Л.Энх-Амгалан гишүүний хэлсэн цахим орчин, интернет орчин дахь зохиогчийн эрх, бүх төрлийн франчайзын асуудал бас их чухал байгаад байгаа.

Тэгэхээр шинэ хуулийн төсөлд маань хуучин хуультайгаа харьцуулахад оюуны өмчийг үнэлэх, оюуны өмч болон аж үйлдвэрийн өмчийг эргэлтэд оруулах, үнэ цэнийг өсөх ямар зохицуулалтууд орж байгаа вэ?

Хоёрдугаарт нь, ерөнхийдөө дуу хөгжим, кино бүтээгч гээд энэ иргэдийн нийтийн хэрэглээнд байдаг гол юунуудаас гадна эрдэмтэд, мөн бүх төрлийн ном бүтээл, зохиолчдын эрхийг хэрхэн хамгаалах вэ?

Ер нь ном бүтээлийг хуулбарлах, өөрийн нэрээр энд тэнд тараах гэх мэтийн асуудал маш түгээмэл байдаг. Энэ тал дээр ямар зохицуулалт орж байгаа вэ?

Гуравдугаарт нь, Оюуны өмчийн газар гэж байгууллага байгаа. Тэгэхээр энэ байгууллагын үйл ажиллагаа маань цахим орчин, шинжлэх ухааны технологид хэр уялдаж сайжрах вэ?

Ер нь иргэдээс гэдэг юм уу? Одоо тухайн зохиогчийн эзнээс гомдол хүлээн авах механизм бол их төвөгтэй байдаг байсан. Одоо энэ механизмыг хэр шинэчлэх вэ? Ийм гурван асуултад хууль санаачлагчаас хариулт авъя.

Г.Занданшатар: П.Сайнзориг.

П.Сайнзориг: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Би түрүүн Л.Энх-Амгалан даргын асуултад дутуу хариулсан. Үүнтэйгээ давхар хариултыг өгье.

Мэдээж оюуны өмчийн үнэлгээний асуудал түрүүн Л.Энх-Амгалан гишүүний асуултад хариулах гэж байсан. Илүү их тодорхой болж өгсөн. Цаашдаа яг оюуны өмчийн эрхийн үнэлгээнүүдийг хийх юм бол барьцаанд тавьж болно. Үүгээрээ аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр нэмэгдүүлж болно. Зээл авч болно ч гэдэг юм уу. Эргээд энэ үнэлгээтэй асуудлыг нь тогтоогоод ирэхээр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, иргэний журмаар гэм хороо арилгуулах ч гэдэг юм уу маш олон зүйлүүд нь тодорхой болж ирж байгаа.

Түрүүн Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Л.Мөнхбаатар нарын санаачлан боловсруулсан хууль маань сая 12 дугаар сарын 01-нээс үйлчлээд эхэлсэн. Энэ дээр оюуны өмчийн үнэлгээний асуудал нэлээн тодорхой зохицуулж, хөрөнгийн үнэлгээний институттэй Оюуны өмчийн газар маань хамтарч мэргэшсэн оюуны өмчийн үнэлгээчдийг бэлдэх асуудал аттестатчилах, гэрчилгээжүүлэх асуудал тодорхой тусгаад ирж байгаа. Тэгэхээр оюуны өмчийн асуудлууд шийдэгдэж байгаа.

Дээрээс нь Ц.Мөнхцэцэг гишүүний асуулт буюу маш их техник, технологийн асуудлаас болоод шинэ шинэ ойлголтууд технологийн хөгжлийг дагаад гарч ирж байгаа. Энэ бүх асуудлуудыг энэ дээр хуульчилж байгаа.

Эргээд ном зохиол ч гэдэг юм уу, эдгээрийн бүтээлүүдийг интернет болон бүхий л номын сангаар ч гэдэг юм уу дамжуулах тохиолдолд ишлэлийг хийх, зохиогчийн тэр эдийн болон эдийн бус эрхтэй холбоотой зохицуулалтуудыг нэлээн нарийвчилж энэ дээр орж өгч байгаа гэж хэлж болно.

Гомдлын асуудал бол сая Оюуны өмчийн байгууллага маань сая батлагдсан шинэ хуулийн дагуу бас тодорхой чиг үүрэг нь болж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд хамгаалалтын асуудлыг шийдэж өгөх ёстой. Хамгаалалтыг оюуны өмч, зохиогчийн эрхийн эзэмшигч маань өөрөө хамгаалахаас гадна төрийн эрх бүхий энэ байгууллагуудын арга механизм тодорхой процедурын хувьд ойлгомжтой байх ёстой. Тэгэхээр үүнийг бас Оюуны өмчийн тухай хуулиар нэлээдгүй шийдэж өгсөн.

Дээрээс нь сая энэ долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар Оюуны өмчийн байгууллагын төсөвт ачаалал.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Лхагвын Мөнхбаатар асуулт асууна.

Л.Мөнхбаатар: Оюуны өмчийн харилцааг багц хуулиар цогц байдлаар нь авч үзэж байгаа нь зөв өө.

Ер нь үүнтэй холбоотой харилцаанууд хоорондоо уялдаатай учраас багц байдлаар, цогц байдлаар авч үзэх нь хамгийн зөв зүйтэй юм билээ.

Ер нь дэлхийн олон улсын оюуны өмчийн байгууллага байдаг. Олон улсын оюуны өмчийн байгууллага энд гэрээ конвенцууд олноор гаргадаг. Түүнтэй холбоотой дүрэм, журмуудыг байнга шинэчилж гаргаж байдаг. Тийм учраас үүндээ нийцүүлж ер нь ойр ойрхон өөрчлөлт ордог бас нэг үндэслэл нь бол энэ юм билээ.

Одоо яах вэ, энэ дотор би нэг хоёр зүйлийг бас тодруулчихъя гэж бодоод байна. Оюуны өмч бол зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг гээд ийм өргөн хэрэглээ талаас нь авч үзэх юм бол энэ өөрөө холбогдохгүй салбар байхгүй. Нийгмийн бүх салбартай холбогддог. Тэр битгий хэл гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудалтай ч холбогдоно шүү дээ. Оюуны өмч, зохиогчийн эрхийг хэр хуульчилсан байна тэр газар гадаадын хөрөнгө оруулалт орох таатай нөхцөл нь болж орж байх жишээтэй.

Ийм учраас дэлхийн жишигт нийцсэн оюуны өмчийн хуулийн шинэчлэлүүд нь чухал юм гэж хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, Оюуны өмчийн байгууллага маань өөрөө орон нутагт хөлгүй ийм байгууллага л даа. Төвдөө цөөхөн хэдэн ажилтантай ийм байгууллага байдаг.

Тэгэхээр орон нутагт энэ хуулийн хэрэгжилтийг хангах талаар шинэ зохицуулалтууд орсон уу? Энэ хэрэгжилтийг хангуулах асуудлыг хэрхэн яаж зохион байгуулж байгаа вэ? Орон нутагт хөлгүй байгууллагын хувьд.

Нөгөөдөхөөр төрийн бус байгууллагаар төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх ийм хуулийн зохицуулалт байдаг. Үүнийг энэ хуулиараа хэрхэн хийж өгч, зохицуулж байгаа вэ? Яагаад вэ гэхээр одоо Хөгжмийн зохиолчдын холбоо ч гэдэг юм уу. Тийм ээ. Зохиолчдын хороо гэдэг юм уу. Орчуулагчдын эвлэл гээд олон байгууллагууд байгаад байдаг. Мэргэжлийн. Эрх ашгийг хамгаалах зорилготой. Эдгээр төрийн бус байгууллагуудаар төрийн тодорхой чиг үүргүүдийг нь хариуцуулаад явах боломж энэ хуулиар нээгдэж байгаа юу гэсэн асуулт байна.

Г.Занданшатар: П.Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар таны асуултад хариулъя. Түрүүн бас Ц.Мөнхцэцэг гишүүний асуулттай холбогдож хариулт өгч болохоор байна. Би гүйцээж чадсангүй. Түрүүний цагтаа багтааж.

Энэ долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр өөрийн орлогоор санхүүжиж болохоор Оюуны өмчийн байгууллага дээр бас тодорхой орон тоо нэмэгдүүлсэн. Өнөөдөр Оюуны өмчийн байгууллага маань 31 орон тоотой ажиллаж байгаа. Улсын хэмжээнд. Одоо 59 орон тоотой ажиллаж болохоор. Эргээд иргэдээс ирж байгаа оюуны өмчийн холбоотой эрхийн гомдлыг хүлээж авах, хяналт шалгалтыг өргөжүүлэх чиглэлдээ ажиллана гэдэг зүйлийг хэлье.

Мөн таны асуулт чухал. Орон нутагт хөл байхгүй байгаад байгаа. Тэгэхдээ 2020 оны 01 сарын 23-ны өдөр батлагдсан Оюуны өмчийн тухай

хуулиар шаардлагатай тохиолдолд тодорхой орон нутагт салбар хэлтэс, алба байгуулж ажиллуулж болохоор байж байгаа.

Тэгэхээр эхний ээлжид энэ хуулийн төсөл боловсруулагдаж, батлагдаж байх явцад концепцын хувьд юу яригдаж байсан юм гэхээр томоохон суурьшлын бүсүүд буюу Эрдэнэт, Дархан, эргээд энэ худалдааны боомт дагасан хотууд буюу Замын-Үүд ч гэдэг юм уу иймэрхүү чиглэлүүдэд бас оюуны өмчийн төлөөлөгч ганц хоёр хүнтэй албыг байгуулж энэ оюуны өмчийн эрхийн зөрчлийг илрүүлэх, хамгаалах асуудлыг шийдэж болох юм гэдэг асуудал яригдаж байсан.

Мэдээж орон нутагт хуулийн хэлтсийн дарга нар гэж байдаг. Энд бас Оюуны өмчийн газраас улсын байцаагчийн эрхийг өгч хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бололцоо бас Оюуны өмчийн тухай хуулиар бүрдсэн байж байгаа.

Энэ бүх арга хэрэгслүүдийг ашиглаж цаашдаа оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг илүү их орон нутгийн түвшинд ч гэсэн сайжруулах чиглэлдээ Хууль зүй, дотоод хэргийн яам анхаарч ажиллана гэдэг зүйлийг хэлье. Танд.

Дээрээс нь төрийн бус байгууллагаар оюуны өмчийн чиг үүргийг гүйцэтгүүлэх асуудал чухал байгаа юм. Эргээд Оюуны өмчийн хууль болон Зохиогчийн эрхийн тухай хууль ч гэсэн энэ чиглэлдээ байж байгаа. Жишээ нь, тодорхой чиг үүрэг гүйцэтгэж байгаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн газар байна. Эргээд хамтын удирдлагын байгууллага буюу зохиогчийн эрхийг хамгаалдаг, нэгдэж эрх ашгаа хамгаалж. Эргээд энэ дээрээс олж байгаа үр өгөөжийг зохиогчийн эрхийн бүтээлийнхээ хувь нэмрээр үр өгөөжийг нь хүртдэг ийм хамтын удирдлагын байгууллагуудын эрх зүйн орчин нь тодорхой болж байгаа.

Тэгэхээр энд оюуны өмчийн салбар дахь төр, төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог энэ хуулиуд батлагдсанаар илүү их сайжирна гэдгийг танд хэлье.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Балжиннямын Баярсайхан асуулт асууна.

Б.Баярсайхан: Та бүхэндээ оройн мэнд хүргэе.

Надад гурван асуулт байна. Энэ шинэчлэн баталж байгаа хуулиар зохиогчийн эрхийг зөрчих байдал бүрэн хамгаалагдаж чадах уу? Хамгаалах зохицуулалтыг бүрэн тусгасан гэж үзэж байна уу? П.Сайнзориг дарга аа.

Учир нь миний харахад зохиогчийн эрхийг бүрэн хамгаалахаар байна гэж ерөөсөө харагдахгүй байна. Өнөөдөр соёлын салбарт зүтгээд явж байгаа дуучид байна. Дууг нь YOUTUBE-ээс аваад CD болгоод зарчихдаг. Киночид арай чүү гэж нэг киногоо хийгээд гаргах гэхээр хулгайлаад интернет дээр тавьчихдаг. Тэр битгий хэл “Би чамд хайртай-2” гэдэг кино Оюуны өмчийн газар дээрээс хязгаарлагдаж байсан гэсэн яриа байж байдаг.

Энэ дээр энэ чадаж байгаа юу? Хариуцлага нь чангарч байгаа юу? Хэчнээн хуульдаа байсан ч гэсэн урьд нь хууль хэрэгждэггүй байсан. Эрүүгийн хууль дээр нэг их том үнийн дүнтэй торгуулийн шийтгэлтэй боловч энэ хууль хэрэгждэггүй байсан. Тэгэхлээр энэ дээр бүрэн хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, өв залгамжлагч 50-хан жил бүтээлээ ашиглах онцгой эрхтэй байх юм уу? Энэ 15.3 дээр өв залгамжлагчийн бүтээл ашиглах онцгой эрхийн хугацаа зохиогч нас барснаас хойш 50 жилийн хугацаанд үйлчилнэ гэж заасан байна.

Тэгэхээр өв залгамжлагч 50-хан жил л бүтээл ашиглана. Түүнээс цааш яах юм бэ гэсэн асуулт гарч байна. Миний ойлгож байгаагаар үр хүүхдүүд, өв залгамжлагч нь насан туршдаа хязгааргүйгээр эзэмших, ашиглах ёстой гэж үзэж байна.

Дараагийнх нь, улсын болон төрийн оролцоотой байгууллагын зохиогчийн эрхийн тухайн үед удирдаж байсан дарга нь өөрийнхөө нэр дээр аваад явчихдаг. Энэ бол телевизүүд дээр гардаг. Олон албан газрууд дээр, салбар дээр гардаг. Хуулийн 19 дүгээр зүйлд албан үүргийн дагуу туурвисан бүтээлийг Зохиогчийн эрхийн тухай хуулийн зохицуулалтад орсон байна. Тухайн үед удирдаж байсан дарга нь өөрийнхөө нэр дээр зохиогчийн эрхийг аваад ажлаас гарахдаа түүнийгээ авч гардаг тохиолдол олон байгаа. Энэ асуудлыг яаж зохицуулах вэ?

Оюуны өмчийн байгууллагын ажилтны ур чадваргүй байдлаас бас зохиогчийн эрх зөрчигддөг. Оюуны өмчийг эзэмшүүлж байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: П.Сайнзориг асуултад хариулна.

П.Сайнзориг: Гишүүний асуултад хариулъя.

Тэгээд нэмээд манай ажлын хэсэгт ажилласан Эрдэнэчимэг судлаач, хуульч та нэмж хариулна уу гээд хуралдаан даргалах зөвшөөрвөл нэмж хариулж болох юм.

Мэдээж зохиогчийн эрхийн хамгаалалт нэлээн түвэгтэй асуудал. Би түрүүн хэлсэн. Бас энэ хуулийн гол гарч байгаа шалтгаан бол энэ техник, технологийн хөгжилтэй холбоотойгоор. Энэ нэг талдаа техник, технологийн хөгжил нь сайн зүйл боловч нөгөө талдаа олон сорилтуудыг бүхий л салбаруудад гаргаж байгаа. Үүний нэг нь оюуны өмчийн салбар. Яах аргагүй энэ технологийн хөгжлийг дагаад энэ эрхийн хамгаалалтыг хэрхэн яаж хийх юм бэ гэдэг асуудал байна.

Тэгэхдээ бид бас технологийн давуу талыг ашиглаж оюуны өмчийн хамгаалалтыг илүү их хийх бололцоо нэг талдаа бүрдэх юм. Зохистой харьцаа, асуудлыг хангаж байж эрхийн хамгаалалтын асуудлыг ярина.

Ер нь зохиогчийн эрхийн хувьд эрхээ хамгаалах асуудал тухайн хувь зохиогчийн энэ эрхийг эдэлж байгаа хүмүүст байдаг. Мэдээж эрхээ хамгаалах асуудлуудыг дан ганцаараа явахаасаа гадна хамтын удирдлагын байгууллага

гэдэг зүйлд нэгдэж орж хамгаалуулах асуудал байгаа. Жишээ нь, нэг уран бүтээлч, дуу туурвидаг уран бүтээлч байлаа гэхэд энэ эрхийн хамгаалалтаа хамгаалуулах хамтын удирдлагын байгууллагад орно. Хамтын удирдлагын байгууллага эргээд энэ зохиогчийн эрхийг тэр зөвшөөрөлгүйгээр авч ашиглаж байгаа караоке ч байдаг юм уу, эсвэл холбогдох этгээдэд хандаж эрх ашгийг нь зөрчсөн этгээдээс гэм хорыг нь арилгуулах асуудлыг бас хөөцөлдөөд явах бүрэн бололцоотой байж байгаа.

Энэ хуулийн бас нэг шинэчилсэн гол зохицуулалтуудын нэг нь энэ хамтын удирдлагын байгууллагын чиг үүрэг, эрх зүйн статус. Эргээд олж байгаа орлогынхоо хэдэн хувийг нь зохиогчдод тарааж өгөх. Хэдэн хувийг нь үйл ажиллагаандаа зарах юм бэ гэдэг энэ зохист харьцааг нь олон улсын жишигт нийцүүлж тогтоож өгч байгаагаараа чухал байгаа.

Мэдээж өв залгамжлалын асуудал чухал. Энэ нь олон улсын гэрээ, конвенцдоо нийцүүлж орж ирсэн гэдгийг танд хэлье.

Албан үүргээ гүйцэтгэж явахдаа, ялангуяа төрийн байгууллагуудад гардаг үзэгдлүүд байж байгаа. Үүнийг бас энэ хуулиас гадна.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлж болно. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн үг хэлнэ.

Л.Энх-Амгалан: Энэ хуулийг дэмжиж байгаа юм. Дэмжих бас хэд хэдэн үндэслэл байна.

Хамгийн гол нь бид цаашдаа хөгжих эдийн засгийн чадавх бол энэ оюуны салбар гэж би ойлгож байгаа юм. Тэр тусмаа бид энэ оюуны өмчийн салбар, энэ оюуныхаа өмчийн хүмүүсийнхээ хийж бүтээн патент, шинэ санаа, шинэ бүтээлүүдийг хамгаалахад тодорхой дэвшил гарах ийм хууль болов уу гэсэн ийм хүлээлт байна.

Тэгээд гэгээн цагаан өдрөөр хийгддэг, хамгийн аймшиггүйгээр, хамгийн ичгүүргүйгээр хийгддэг хулгай бол оюуны өмчийн хулгай байгаад байгаа шүү дээ.

Тэгээд энэ танилцуулга дээр нийт гарч байгаа зөрчлийн бараг үндсэндээ 65 хувь нь оюуны өмчийн хулгайтай холбоотой зөрчил байна гэдэг бол энэ их том нөхцөл байдал. Тэгээд эндээс бид бас энэ хүмүүсийнхээ оюуны өмчийг хамгаалах чиглэл рүү шинэ дэвшил гаргах ёстой гэдэг дээр зайлшгүй энэ хууль тодорхой үр дүнгээ өгөх ёстой гэж би ойлгож байгаа.

Өнөөдөр сүлжээндээ нэг ч зочид буудалгүй B&B компани бол хамгийн том зочид буудлын захиалгын компани болчихдог. Нэг ч таксигүй, хувьдаа таксигүй UBER гээд компани одоо хамгийн том таксины сүлжээний компани болчихдог. Гэх мэтчилэнгээр цаашдаа оюуны патент, оюуны салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтуудын асуудлыг хамгаалах чиглэл рүү, эрх зүйн

чиглэл рүү бид үнэхээр зайлшгүйгээр төр анхаарлаа хандуулах цаг нь үнэхээр болсон байна гэж би хараад байгаа юм.

Тийм учраас ер нь ингээд цаашдаа энэ оюуны өмчийн бүртгэлийн асуудлууд, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг олноор нь ажиллуулах, бэлтгэх энэ чиглэл рүү тодорхой өөрчлөлтүүдийг хийх ийм зайлшгүй шаардлагууд байна гэж харж байгаа.

Тэгээд мэдээж энэ хуулиар цаашдаа оюуны өмч, шинээр патент бүтээж байгаа энэ хүмүүс банкнаас зээл авах оюуныхаа өмч, патентуудыг барьцаалах, яг зах зээлийн үнэлгээгээр үнэлүүлэх энэ боломжууд нь гарч ирэх юм байна.

Хамгийн гол нь сайхан хууль хийх нэг өөр. Хамгийн гол нь хуулийн хэрэгжилт гэдэг бол хамгийн чухал асуудал байдаг учраас энэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэл рүү бид бас олон зүйлийг анхаарч ажиллах ёстой. Монгол Улс үнэхээр оюуны өмчийн хулгай нүүрлэсэн ийм улс болчихоод байгаа шүү.

Бид оюуны өмчийн хамгааллынхаа асуудлаар нэлээн сүүл мушгиж явж байгаа ийм улс орон байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилт тал дээр бид зайлшгүй анхаарал хандуулах ёстой гэж хэлэхийг хүсэж байна. Ингээд энэ хуулийг дэмжиж байна.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Балжиннямын Баярсайхан үг хэлнэ.

Б.Баярсайхан: Баярлалаа. Сая асуулт маань ч дутуу боллоо. Хариулт маань ч дутуу боллоо. Гэхдээ би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Тэгээд цаашдаа энэ хуулийн хэрэгжилт дээр саяын Л.Энх-Амгалан гишүүний хэлсэн зүйлийг бас анхаараад. Дээрээс нь Монголын уран бүтээлчид энэ шинэ технологи, инноваци, энэ старт-ап гээд л одоо бид шинжлэх ухааныхаа салбарыг, соёлын салбараа хөгжүүлэе. Олон шинэ шинэ бүтээл гаргая гээд л ингэж байна. Гэтэл хамгийн их айдастай юм бол Монгол хүмүүсийн хувьд энэ санаа маань, идея маань, энэ бүтээл маань миний өмч байж чадах уу гэдэг дээр, үүнийг хууль хамгаалж чадах уу гэдэг дээр өнөөдрийг хүртэл итгэлгүй байдаг юм.

Тийм учраас энэ хуулийг улам чамбайруулж төрийн байгууллагуудын уялдаа холбоог нь сайжруулж илүү сайн хууль болгоход бүгдээрээ хамтран анхаарч ажиллая.

Тэгээд энэ хуулийг сайн хууль болгоно гэж итгэж байна. Тэгээд дэмжиж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ хууль бол цаг үеэ олсон их чухал хууль орж ирж байгаа учраас үүнийг дэмжиж байна.

Тэгээд ер нь сүүлийн энэ эрчимтэй технологийн хөгжил, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал бол бүс салбарт эрх зүйн зохицуулалтыг яаралтай хийх шаардлагатай байгаа. Тэр дотроо энэ оюуны өмчийн эрх зүйн асуудал, энэ зохицуулалт ерөнхийдөө Монгол Улсын хувьд ч гэсэн бас нэлээд зөрчил, бэрхшээлтэй явж ирсэн байгаа.

Ер нь энэ зохиогчийн эрхийн зөрчил нэлээд түгээмэл байдаг. Үүнийг бид багасгах, бүх бүтээл ном хуулбарлах, бүх салбаруудад зохиогчийн эрхийг баталгаажуулах. Дээрээс нь хамгийн гол үндэс нь бол энэ нөгөө зохиогчийн эрхийн оюуны өмч гэдэг юм уу, аж үйлдвэрийн өмчийг үнэ цэнийг нэмэгдүүлж эдийн засгийн эргэлтэд оруулахад энэ шинэ хуулийг бид их сайн баталж өгөх нь цаг үеэ олсон чухал зүйл болно. Ингэж байж бид шинэ зуунд технологийн болоод инновацийн үйл ажиллагааг амжилттай хийх ёстой.

Тийм учраас энэ хуулийг дэмжээд цаг үедээ нийцсэн, мөн шинэ зохицуулалтуудыг, олон улсын чиг хандлага, олон улсын эрх зүйн ерөнхий зохицуулалтад нийцсэн байдлаар гаргах ёстой гэсэн байр суурьтай байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Патентын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуулийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бид Байнгын хорооны саналаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Ингээд Байнгын хорооны саналаар Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 36 гишүүн дэмжиж, 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар 18.00 цаг хүрсэн бол чуулган завсарлана. Цааш нь үргэлжлүүлж хуралдах эсэхийг олонхийн санал хураалтаар шийдвэрлэнэ гэсэн заалттай.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Маргааш 10.00 цагт. 09.00 цагаас чуулганы нэгдсэн хуралдааны бэлтгэлийг хангах ажлууд явагдана. 10.00 цагт Патентын тухай хуулиар. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг. Хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслөөр хэлэлцүүлэг үргэлжилнэ.

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД